



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 05

Хажуу шинэ ус

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл  
ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сумын мал сүргийг 2020 онд шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу чанартай хийж гүйцэтгэхийг “Угтаал чандмань” хоршооны малын их эмч (Д. Амгалан)-д үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох байгууллагад тухай бүр тайлан мэдээг хүргүүлж, хэрэгжилтийг ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг сумын мал эмнэлгийн тасгийн дарга (А. Бямбадорж)-д даалгасугай

ДАРГА  В.НЯМСҮРЭН



4802190000

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2020 оны 04 сарын 15 өдрийн  
05 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬ-УГТААЛ СУМЫН МАЛ СҮРГИЙГ 2020 ОНД ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН  
СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Баг болон МЭҮН нэр	Угаалганд хамрагдах			Хорхойгүйтгэл /туулгалт/				Гадна шимэгчтэх, гууртах боловсруулалт					Өрхийн тоо	Хамрагдах мал						
		Бүгд	Тэмээ	Бог	Бүгд	Адуу	Тэмээ	Нохой	Бог	Бүгд	Адуу	Тэмээ	Үхэр		Бог	Бүгд	Бог	Адуу	Тэмээ	Үхэр	Нохой
1	Угтаал чандмань хоршоо	25200	200	25000	30750	500	0	250	30000	32750	200	50	500	32000	200	86900	85200	700	250	500	250
ДҮН		25200	200	25000	30750	500		250	30000	32750	200	50	500	32000	200	86900	85200	700	250	500	250